



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

**Г Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.4.3, 6.4.4, 6.4.6, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Цагдаагийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тэмдэглэлээр тогтоогдсон, 1,600,847.84 (нэг сая зургаан зуун мянга найман зуун дөчин долоон төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 277,925.00 (хоёр зуун далан долоон мянга есөн зуун хорин таван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах, материалыг ялган тоолж, ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004553  
7-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 22 дугаар сарын 6-ны өдрийн  
95 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ  
ХАНГАХ АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон, бүртгэсэн он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Харуулын сэндвичэн байр, (БНСУ-ын ЭСЯ-ны /хуучин нэрээр/ гаднах) Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо	2013/2018	1,600,847.84	м2	7.5	1,600,847.84	277,925.00	1,322,922.84
	Нийт дүн					1,600,847.84	277,925.00	1,322,922.84